


ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1	<p>Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (уялдаа, холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)</p> <p>Монгол Улсад эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээг сайжруулах</p> <p>B6230 2017.04.10</p>	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилго</p> <p>Люксембургийн Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сангийн санхүүжилтээр Монгол Улсад эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээг сайжруулах.</p>
2	<p>Санхүүжилтийн эх үүсвэр</p> <p>Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сан</p>	<p>Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж</p> <p>Буцалтгүй тусламж</p>
3	<p>Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа/</p> <p>Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сан /3 жил 2019.09 хүртэл/</p>	<p>Үндсэн хэрэгжүүлэх байгууллага</p> <p>ЭМХТ, ЭХЭМҮТ, АШУҮИС-ийн багш, эмч нарын бүрэлдэхүүнтэй хамтарсан 28 гишүүнтэй ажиллаж байна.</p>
		<p>Зорилт 1.</p> <p>Ухаалаг утасны аппликэйшны агуулгыг боловсруулж, хөгжүүлэх</p> <p>Зорилт 2.</p>

4	<i>Төсөл хөтөлбөрийн зорилтууд</i>			<p>Зайн сургалтын платформыг шинэчлэн боловсруулах</p> <p style="text-align: center;"><i>Зорилт 3.</i></p> <p>Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай өртөг тогтоох аргачлалыг боловсруулах</p> <p style="text-align: center;"><i>Зорилт 4.</i></p> <p>Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн захиалгын үндэсний нэгдсэн сүлжээг боловсронгуй болгох</p>					
5	Зардал	<i>Төсөв (нийт шаардагдах зардал)</i>	<i>Төсөв</i> 131,598 USD – 319,390,773 төгрөг	<i>Гүйцэтгэл</i> 187.723.400			<i>Хувь</i> 100%		
		<i>Үүнд:</i>							
		<i>Багц 1</i>							
<i>Төсөл хөтөлбөрийн зорилт:</i>				<i>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ</i>					
6	<p><i>1-р зорилтын хүрээнд:</i></p> <p>Ухаалаг утасны аппликэйшны агуулгыг боловсруулж, хөгжүүлэх</p>			<p><i>1- р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эмчийн гарын авлага, эх, нярайд зориулсан веб хуудас, мобайл аппликэшин програм хангамж хөгжүүлэх” ажлыг Товэр Софт компанитай хамтран хийж гүйцэтгэн 2019 оны 4 дүгээр сард НҮБХАС-нд эх код болон ажиллах заавар журмын хамт хүлээлгэн өгсөн. Мөн тус аппликэйшныг ЭХЭМҮТ-д хүлээлгэн өгсөн бөгөөд цаашид ЭХЭМҮТ үйл ажиллагааг хариуцсан ажиллах юм.</i></p>					
<p><i>2-р зорилтын хүрээнд:</i></p> <p>Зайн сургалтын платформыг шинэчлэн боловсруулах. Эх барихын яаралтай тусламж, эх ургийн анагаах ухаан, өсвөр үе залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсруулах</p>				<p><i>Төгсөлтийн дараах “Эх ургийн анагаах ухаан”, “Өсвөр үе судлал” төрөлжсөн мэргэшлийн, Эх баригчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг төвийн Ерөнхий захирлын А/76 дугаар тушаалаар байгуулан ажилласан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлал, Эх барих эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн төлөөлөл оролцсон боловсруулсан. Боловсруулсан 3 чиглэлийн сургалтын хөтөлбөрийг ЭМЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлөөр хянуулах, ЭМЯ-</i></p>					

	<p>ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай өртөг тооцох аргачлалыг боловсруулах</p>	<p>Шинэ техник технологи нэвтрүүлэх замаар эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Жирэмсний хяналт, перинаталь скринингийн өртөг тооцох, санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгцээг төсөвт хэрхэн тусгах тухай гарын авлагыг боловсруулж гүйцэтгэсэн. Өртөг тооцох ажлын хүрээнд жирэмсний хяналт перинаталь скринингийн бодит өртөг, 338-р тушаалын дагуу үзлэг, шинжилгээ, зөвлөгөө өгөхөд шаардлагатай норматив өртөг, өртөг тооцох аргачлалыг нэгтгэж аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын эдийн засагч санхүүчдэд зориулсан гарын авлага бэлтгэх ажлуудыг зохион байгуулж ажилласан. Аргачлал дээр ДЭМБ-ын үндэсний тооцооны бүсийн зөвлөх ФеВидагаас зөвлөгөө авч ажилласан. Аргачлал, судалгааг аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын санхүүгийн мэргэжилтнүүдэд танилцуулж санал зөвлөмж авсан. Тэдний саналд дахин ажлын хэсэг байгуулж аргачлалыг бодит байдалтай уялдуулах нь зүйтэй гэсэн. Иймд эх барих, эдийн засагч, санхүүч мэргэжилтнүүдийг оруулан аргачлалыг илүү бодитой, үндэслэлтэй болгохоор ажиллаж байна. Аргачлалыг эцэслэсний дараа ЭМЯ, НҮБХАС-д танилцуулсан. Тус гарын авлагад төсөвт үзүүлэх урт хугацааны нөлөө буюу “Budget impact analysis” дүн шинжилгээ хийх бүлэг нэмж оруулсан. Гарын авлагыг ЭМХТ-ийн Эрдмийн зөвлөл, ЭМЯ-ны дэргэдэх Эрүүл мэндийн эдийн засаг, санхүү, удирдлагын мэргэжлийн салбар зөвлөлөөр батлуулахад бэлтгэн 2020 оны 2 сард хэвлүүлэн түгээх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>
<p>4-р зорилтын хүрээнд:</p> <p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээ, шаардлагатай тоног төхөөрөмжийн судадгаа хийх, шаардагдах багаж, тоног төхөөрөмжийг худалдан авч нийлүүлэх</p>	<p>4-р зарилтын хүрээнд Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээ болон бүртгэл, мэдээний сангийн програм хангамж танилцуулах сургалтыг цахимаар 2 удаа орон даяар зохион байгуулсан. Эх, нярайн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн инженерүүдийг хамруулсан. ЭМХТ-ийн захирлын 2018.05.23-ны өдрийн А/70 дугаар тушаалаар “Эх, нярайн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг шалгах тест багажийг худалдан авах” ажлын хэсэг байгуулагдаж, суурь судалгааг хийж 2018.12.14-ний өдөр худалдан авах тендер зарлагдсан. ЭМХТ-ийн ерөнхий захирлын 2019.09.16-ны өдрийн А/130 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг ЭМС-ын А/409 дүгээр тушаалаар хуваарилагдсан 73,694,300 төгрөгийн үнэ бүхий өвчтөний хяналтын монитор шалгах симулятор + ургийн монитор шалгагч – 1, фото эмчилгээний аппаратны</p>

		<p>радиометр - 2, кварцын гэрлийн радиометр – 4 ширхэгийг 2019.09.16-ны өдөр хүлээн авсан.</p>  <p>Шалгалт тохируулгын симулятор, анализаторыг 3 нэр төрлөөр нэмэгдүүлж, 2020 оноос эхлэн ургийн монитор, фото эмчилгээний аппарат, зөөврийн болон суурин нян устгах гэрэлд шалгалт тохируулга хийх боломж бүрдсэн. Гүйцэтгэл 100 хувь.</p>					
7	<p>Дүгнэлт (дутагдал, анхаарах асуудлууд</p> <p>Төсөл амжилттай хэрэгжиж байна.</p>						
8	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх</p>	<p>Захиалагч байгууллага болох НҮБ-ын Хүн амын сангийн мэргэжилтүүдтэй тогтмол хамтран ажиллаж арга зүйн болон нэмэлт мэдээлэл авч ажилласан.</p>					
9	<p>Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт</p>	<p>Биелэлтийн дундаж</p> <p>98.7%</p>	<p>Зорилтын тоо</p> <p>4</p>	<p>Зорилт 1</p> <p>100%</p>	<p>Зорилт 2</p> <p>100%</p>	<p>Зорилт 3</p> <p>95%</p>	<p>Зорилт 4</p> <p>100%</p>
10	<p>Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ/</p>						

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ